



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/63

Бүрэн сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цайны хоол хүнсний материал нийлүүлэх тендер шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Ж.Пүрэв-Очир

(Засаг даргын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Г.Ундрах-Эрдэнэ

(Соёлын төвийн эрхлэгч)

Н.Хүрэлбаатар

(Мал эмнэлгийн улсын байцаагч)

Ж.Түмэнжаргал

(Иргэний төлөөлөл)


Нарийн бичгийн дарга:

Б.Азжаргал

(Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер)

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Пүрэв-Очир)-д ашиг сонирхолын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг чанд баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ТҮВШИНБАТ

412305141